

ХИЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖЛИЙН ТҮҮХ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

HISTORY AND CURRENT STATUS OF THE DEVELOPMENT OF BORDER STUDIES AS A FIELD OF STUDY



Хил Судлалын Шинжлэх Ухааны Хөгжлийн Түүх, Өнөөгийн Байдал

Н.Наранжамц

Дотоод хэргийн их сургуулийн Хүндэт профессор, тус их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, Монгол Улсын Гавьяат багш, Цэргийн ухааны доктор, профессор, хурандаа

Naranjamts N.

Honorary Professor at the University of Internal Affairs, Senior Lecturer in the Department of Border Service Management and Strategy at the University's Management Academy, Honored Teacher of Mongolia, Doctor of Military Sciences, Professor, and Colonel

Т.Баяр-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор, Хил судлалын докторант, хошууч

Bayar-Erdene T.

Professor, Department of Engineering and Technology, Border Service School, University of Internal Affairs, Major

*хариуцлагатай зохиогч: Naranjamts1009@gmail.com

Хураангуй: Хил судлалын шинжлэх ухаан нь улсын хил, түүний бодлого, хил хамгаалалт, хилийн аюулгүй байдалтай холбогдох олон талт асуудлыг улс төр, эдийн засаг, нийгэм, хууль эрх зүй, цэрэг техник, аюулгүй байдал, хөгжлийн орчны хүчин зүйлийн хамт судална. Энэ шинжлэх ухаан нь геополитик, геостратеги, олон улсын харилцаа, түүх, хууль эрх зүй, хил хамгаалалтын онол, цэрэг хүчний байгуулалт, алба-байлдааны ажиллагаа гэх мэт олон чиглэлийг нэгтгэдэг.

Abstract: Border studies involve the examination of a state's borders, including their policies, border protection, and security measures. This field encompasses various factors such as political, economic, social, legal, military, and developmental aspects. It integrates multiple disciplines, including geopolitics, geostrategy, international relations, history, law, border protection theory, military force development, and military operations.

Түлхүүр үг: Хил судлал, хилийн шинжлэх ухаан, хил хамгаалалтын онол, хил хамгаалах урлаг, Хил хамгаалах байгууллага.

Keywords: Border studies, border science, border protection theory, border protection art, and the Border Protection Organization.

Удиртгал

Өнгөрсөн зууны 1995 оны 12 дугаар сарын 06-ны өдөр “Хил судлалын шинжлэх ухаан”-ыг Олон Улсын Оюуны бүтээлийн танхим (Международная палата интеллектуальной новизны)-д EIW 0001175 дугаартайгаар бүртгэн авсан нь олон улсын түвшинд Хил судлалын шинжлэх ухааныг хүлээн зөвшөөрсөн өдөр гэж тэмдэглэдэг.

Хил судлалын шинжлэх ухааныг манай хойд хөрш илүүтэй хөгжүүлж, тэргүүлж байгаа бөгөөд ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Хилийн албаны академи, Москвагийн хилийн дээд

сургуулийн 50 гаруй эрдэмтэн судлаачид 1996 онд ОХУ-д Хил судлалын хүрээлэн байгуулж, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний асуудлыг эрхлэн, хил судлалын эрдэмтдийг бэлтгэж эхэлсэн байдаг.

Монгол Улсад анх 1998 онд хил судлалын судлах зүйлийн хүрээнд бичигдсэн “Хилийн операци” бүтээлд хилийн шинжлэх ухааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон бөгөөд 2000 оны эхээр доктор Г.Дагважамц, тухайн үеийн Хилийн цэргийн штабын дарга, генерал С.Гүржав, түүний орлогч, Хилийн



ХИЛ СУДЛАЛ

хэлтсийн дарга (тухайн үед ОХУ-ын Хилийн албаны академийг төгсөөд удаагүй байсан) Н.Наранжамц нартай доктор, генерал П.Дашийн өгсөн чиглэлийн дагуу уулзаж, хил судлалын тухай санал солилцож, улмаар Хил судлалын нийгэмлэг байгуулах, тухайн үеийн нэр хүнд бүхий иргэний төлөөлөл, эрдэмтдийг оролцуулах, дүрэмтэй байх гэх мэт асуудлаар тодорхой зөвшилцөлд хүрснээр 2000 онд Хил судлалын үндэсний нийгэмлэг байгуулагдаж, улмаар 2001 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академи” (цаашид МОУА)-ийн ерөнхийлөгч, академич Александр Григорьевич Харитоновтой Москва хотноо Ш.Арвай, П.Даш нар уулзаж, “Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг”-ийг түшиглэн “МОУА”-ийн салбар байгуулж болох тухай тухайн үеийн Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдын албан бичгийг гардуулж, хамтын ажиллагааны тунхаглалд гарын үсэг зурснаар Мэдээлэл Судлалын Монголын Академи байгуулагдах үндэс тавигдсан болно.

Энэ ажиллагаанд Цэргийн шинжлэх ухааны доктор, Ш.Арвай, доктор П.Даш, доктор Д.Нямдорж, доктор А.Муратхан нар тэргүүлэх байр суурьтай оролцсон байдаг.

“МОУА” нь Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд хил судлалын ухааныг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд тэргүүлэх байр суурьтай оролцож байсан зарим эрдэмтэн, мэргэдийг МОУА-ийн “Академич”, “Жинхэнэ гишүүн”, “Сурвалжлагч гишүүн” гэх мэт зэрэг, дэв олгож байсан болно.

Хил судлалын шинжлэх ухааны агуулга, бүрэлдэхүүн хэсгүүд тодорхойлогдож системчлэгдэн, хил судлалын мэдлэгийн сан хөмрөг арвижин шинжлэх ухааны бие даасан салбар болж, Хилийн цэргийн дээд сургууль бие даан сургалт, судалгааны ажил эрхэлж, Хил судлалаар цэргийн ухааны магистрын зэрэг олгох сургалт явуулж эхэлсэн (ХЦДС-ийн Эрдэм шинжилгээний төв, Сургалтын алба). Улмаар Дотоод хэргийн их сургууль байгуулагдсанаар БСШУ-ны сайдын 2010

оны 235 дугаар тушаалаар “Хил судлал”-ын ухаанаар магистр, докторын сургалт эрхэлж, эрдмийн зэрэг, цол хамгаалах нөхцөл бүрдсэн юм.

Өнөөдрийн байдлаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлийн, чиглэл, индексийн жагсаалтад Хил судлалын бакалавр, магистр, докторын зэрэг олгох чиглэл багтсан бөгөөд Хилийн албаны сургууль Хил судлалын бакалавр, магистр, докторын сургалтыг Ахисан түвшний сургалт, судалгааны албатай хамтран явуулж байна.

Үндсэн хэсэг

Хилийн шинжлэх ухаан нь 1990-ээд оны дунд үеэс янз бүрийн улсуудад төрөл бүрийн түвшинд харилцан адилгүй хөгжиж эхэлсэн бөгөөд Монгол Улсад 30 шахам жил хөгжиж байна.

Хилийн шинжлэх ухаан гэж юу болох, түүний үүсэл, судлах ерөнхий зүйлийг хурандаа Н.Наранжамц (Хилийн цэргийн Штабын орлогч, Хилийн хэлтсийн дарга) 1998 онд бичсэн “Хилийн операци” бүтээлдээ дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1.Улсын хил, түүний үүсэл хөгжил, хөгжлийн үе шатууд буюу түүхийн салбар;

2.Улсын хилийн тодорхойлох, тогтоох, тэмдэглэх, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд баталгаажуулах цогцолбор асуудлыг судлах хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;

3.Улсын хил хамгаалалтын онол, урлагийн мөн чанар, агуулга, бүрэлдэхүүн хэсгийг судлах;

4.Улсын хил хамгаалалт нь үндэсний болон улсын аюулгүй байдлын системд гүйцэтгэх үүрэг, эзлэх байрыг тодорхойлох;

5.Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг боловсруулах, тодотгох, өөрчлөх бусад төрийн бодлоготой уялдуулах;

6.Хилийн гадаад харилцааны үндсэн чиг шугамыг тодорхойлох, хилийн орон зайд тогтвортой аюулгүй байдлыг бий болгох үзэл баримтлал, арга замыг тодорхойлох;

7.Хилийн тухай олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн үндсэн зарчмуудыг тодорхойлох, хилийн асуудалтай холбоотой бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх;

8.Улсын хилийг хамгаалахад улс төр, эдийн засаг, дипломатын, тагнуулын, цэргийн, дэглэмийн, хууль эрх зүйн, захиргааны, санхүү-эдийн засгийн, материал, инженер техникийн мэдээллийн эх сурвалжуудыг чиглүүлэх ерөнхий арга замыг тодорхойлох зэрэг асуудлуудыг тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хил судлалыг хөгжүүлэх, түүнийг олон улсын жишигт хүргэх, ингэснээр эх орныхоо хил, хилчид, хязгаар нутагт аж төрж, хөдөлмөрлөж буй хүмүүсийн үйл ажиллагаа, үзэгдлийн мөн чанарыг судалж, харилцан мэдээлэх, мэдээллийн цоо шинэ орчныг буй болгож, төрийн хилийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд туслах зорилгоор 2000 онд “Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг” төрийн бус байгууллагыг байгуулах анхны хурлаа хийж байжээ. Тус хурлаар Тэргүүнээр улс төр судлалын доктор, дэд профессор Г.Дагважамцыг, нарийн бичгийн даргаар Батлан хамгаалахын их сургуулийн Хилийн цэргийн сургуулийн Хил хамгаалалтын тэнхимийн ахлах багш, дэд хурандаа Д.Нямдорж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, түүхийн ухааны дэд доктор Д.Шүрхүү нарыг тус тус санал нэгтгэйгээр сонгон баталж, удирдах зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Гишүүдэд ЦШУ-ны дэд доктор, дэд профессор, дэслэгч генерал Ш.Арвай, төрийн шагналт зохиолч Б.Догмид, З.Дорж, генерал Б.Цийрэгзэн, ХЦС-ийн захирал, дэд профессор, хошууч генерал Я.Пүрэвдорж, дэд захирал, дэд профессор хошууч генерал П.Даш, УГЕГ-ийн дэд дарга Ш.Цогтоо, ХЦС-ийн тэнхимийн эрхлэгч ЦШУ-ны дэд доктор, профессор хурандаа А.Муратхан, П.Баттогтох, “Сутай” хууль зүйн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, дэд профессор Со.Бадарчи, МУИС-ийн багш, түүхийн

ухааны дэд доктор, профессор И.Саруул, ХЦУГ-ын Газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ХЦУГ-ын ССХХ-ийн орлогч дарга, дэд хурандаа А.Батсайхан нарыг томилов. (Хил судлал, 2000)

Хил судлалын шинжлэх ухааныг Монгол Улсад дэлгэрүүлэх, хилчид төдийгүй өргөн олон нийтийн хүртээл болгоход 2000 онд доктор, тэргүүлэх профессор Г.Дагважамцын үүсгэн санаачилсан, доктор, профессор Ц.Ганболдын одоо эрхэлж буй онол-арга зүй, танин мэдэхүйн “Хил судлал” сэтгүүл ихээхэн үүрэг гүйцэтгэв. Энэ сэтгүүл нь 921 тоот улсын бүртгэлийн дугаар, 14921 тоот индекс, ISBN: 978-99973-41-65-5 код бүхий бөгөөд 25 дахь жилдээ хэвлэгдэн, хилчдэд хил судлалын шинжлэх ухааны шинэ мэдлэг түгээж, оюуны хөрөнгө оруулж байна. (Ц.Ганболд, 2022-12-02)

Монгол улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны 20 дугаар тогтоолоор “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг Мэдээлэл Судлалын Монголын Академи, Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг, Хилийн Цэргийн Дээд Сургуулийн эрдэмтэн судлаачид Хил Хамгаалах Ерөнхий Газар, Газрын штаб, түүний Хилийн хэлтэс, Захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран боловсруулж батлуулан мөрдөж эхэлсэн. /2/ хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох;/ (Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002)

Хил хамгаалах байгууллагаас 1980-1990-ээд онд төрсөн эрдэмтэд болох Б.Цэдэн-Иш, Ш.Арвай, Ц.Пүрэв, Д.Базарсад, А.Муратхан, Ц.Энхжаргал, Г.Дагважамц, П.Баттогтох, П.Даш, С.Гүржав, П.Сүндэв, Н.Осор, К.Анаргүл, Хилийн түүх судлаач, хожим доктор болсон Э.Лувсанбалдан нар хил судлалын шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг, цол хамгаалахад үлгэр дуурайлал болж, өөрсдийн үнэтэй хувь нэмрээ оруулсан байдаг.

Улмаар хилийн цэрэгт ажиллаж байсан олон офицерууд эрдэм судлалд





Хил судлалын шинжлэх ухааны бие даасан салбар болсон гэж үзэж “Хил судлал”-ын шинжлэх ухаанаар магистр, докторын зэрэг хамгаалах, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын тушаал

шамдаж, хил судлалын үндсэн чиглэлээр судалгааны ажил бичиж, тухайн үед хил судлалын ухааныг хүлээн зөвшөөрч, хамгаалах эрх нээгдээгүй байсантай холбогдуулан Батлан хамгаалахын их сургуулийн дэргэдэх Цэргийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл дээр диссертациудаа хэлэлцүүлж хамгаалж ирсэн байдаг. Энэ нь 1990-ээд оны сүүлээс 2010 он хүртэлх хугацааг хамрах бөгөөд энэ хугацаанд Хилийн цэргийн дээд сургуулийн эрдмийн зөвлөлөөс багш нараа эрдэмжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж 10 шахам багш нар эрдмийн зэрэг хамгаалсан байдаг. Тэдгээрийн тоонд хурандаа Б.Бат-Эрдэнэ, дэд хурандаа Л.Батжав, дэд хурандаа Ц.Ганболд, дэд хурандаа Д.Нямдорж, хурандаа Б.Лхагва, хурандаа Н.Наранжамц, хурандаа Ж.Өвгөнбүргэд, хурандаа И.Сэржхүү, хурандаа В.Жавхланцогт, хурандаа Д.Дашдаваа, хурандаа Ц.Одбаяр, дэд хурандаа Г.Хулан, хурандаа Ж.Жамсрандорж, Хил хамгаалах байгууллагад ажиллаж байсан хурандаа Х.Жекей, бригадын генерал Д.Ганбаатар, хошууч генерал Ш.Лхачинжав, хурандаа

М.Лхагвасүрэн, дэд хурандаа Н.Даваадорж, хурандаа Д.Чойбаатар, хурандаа Ц.Гансүх, хурандаа А.Ганбилэг зэрэг эрдэмтэд хил хамгаалалтын онолын асуудлаар докторын зэрэг хамгаалж, Хил судлалын шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулжээ.

Мөн бусад шинжлэх ухааны чиглэлээр доктор О.Нэмэхханд, Ц.Батбаяр, Г.Лхагвамаа, Б.Эрдэнэ-Очир, Ц.Цэрэндорж, Д.Баттүшиг, Д.Алтангэрэл нар амжилттай хамгаалж, хил судлалын ухаанд зохих хувь нэмрийг оруулсан болно.

Хил судлалын шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсгүүд тодорхойлогдож системчлэгдэн, бүрэн ойлгомжтой мэдлэг хуримтлагдаж шинжлэх ухааны бие даасан салбар болсон гэж үзэж “Хил судлал”-ын шинжлэх ухаанаар магистр, докторын зэрэг хамгаалах, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын “Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэх тогтоох тухай” 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 235 тоот тушаал гарсан билээ.

**МОНГОЛ УПСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 05 сарын 20 өдөр Дугаар 235 Улаанбаатар хот

Мэргэжлийн чиглэл, индекс
шинэчлэн тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх өрөөний мэргэжлийн чиглэл, индексийг нэгдүгээр, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн жагсалт, мэргэжлийн түвшин, зэргийг хоёрдугаар, Сургалтын байгууллагын мэдэлд үлдэх мэргэжлийн чиглэл, индексийг гуравдугаар, Эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр төрөлжүүлэн зэмсгүүдэх мэргэжлийн чиглэл, индексийг дөрөвдүгээр хавсаргалаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Шинэчилсэн мэргэжлийн чиглэл, индексийг 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар М.Баасанжав, холбогдох сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.
3. Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэгдсэнтэй холбогдуулан оюутны суралцаж буй мэргэжлийн чиглэл, индекс өөрчлөгдсөн тохиолдолд оюутныг тухайн мэргэжлээр төгсөх хуртлал нь үргэлжлүүлэн суралцуулахыг холбогдох сургуулийн захирал нарт зөвшөөрсугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 2005 оны 191 дүгээр тушаалыг хүчингүй болгонд тооцсугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжаат үүрэг даалгасугай.

САЙД  Ө.ОТГОНБАЯР

D	E		86	12	00	Ар талын алба
D	E		86	13	00	Хуягт танны алба
D	E		86	14	00	Химийн алба
D	E		86	15	00	Авто, гинжит машины алба
D	E		86	16	00	Холбооны алба
D	E		86	17	00	Зэвсгийн алба
D	E		86	18	00	Цэргийн инженерийн алба
D			86	19	00	Хилийн алба
D			86	20	00	Шалган нэвтрүүлэх алба
D			86	21	00	Хөгжмийн алба
D	E		86	22	00	Батальон /дивиз-ы түвшний алба, бэлтгэл, мэргэжил дээшлүүлэлт
	E	F	86	23	00	Стратеги тактик, команд-штаб
	E		86	24	00	Хороо /бригад-ны түвшний алба, бэлтгэл, мэргэжил дээшлүүлэлт
	E		86	25	00	Стратеги /дэдд/ дамжаа
	E	F	86	25	00	Хил судлал
D			86	26	00	Криминалистикийн шинжилгээ-эрх зүй
D			86	27	00	Дотоодын цэргийн ажил-эрх зүй
D	E		86	28	00	Радио электрон тэмцэл
	E	F	86	29	00	Цэргийн зэвсэглэл, техник
	E	F	86	30	00	Цэргийн түүх
D	E		86	31	00	Цэргийн байр зүй

Зураг-1.БСШУ-ны Сайдын 2010 оны 235 дугаар тушаал

Эх сурвалж: (БСШУ-ны Сайдын тушаал, 2010)

Тушаал батлагдсанаар Хил судлалын ухаанаар магистр, докторын сургалтыг бие даан зохион байгуулах, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдыг бэлтгэх

нөхцөл бүрдэж, 2011-2012 оны хичээлийн жилээс элсэлт авч 2013 онд анхны 20 офицер Хил судлалын магистрын зэрэг хамгаалж, өнөөдрийн байдлаар 200 гаруй

хилчин хил судлалын магистрын зэрэг хамгаалжээ. (М.Баярсайхан, 2019)

Хил судлалын ухаан 2010 он хүртэл дээрх байдлаар хөгжин, төлөвшиж ирсэн нь цаашид хил судлалын ухаанаар бие даасан эрдэм судлалын ажил эрхэлж, хил судлалын ухааны эрдэмтэн, судлаач төрүүлэн гаргах үндсэн нөхцөл бүрдсэн.

Хил судлалын чиглэлээр докторын сургалтыг 2013-2014 оны хичээлийн жилд эхлүүлж, 70 шахам докторант элссэнээс 2025 оны байдлаар 12 судлаач докторын зэргээ амжилттай хамгаалаад байна.

Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлд Хил судлалын докторын зэрэг хамгаалуулах эрх олгогдсоноор 2019 онд хурандаа Ё.Хадхүү “Оперативын чиглэлд хилийн эрэл явуулах ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдвээр анхны Хил судлалын докторын зэрэг хамгаалсан.

Ийнхүү хил судлалын ухаанаар бригадын генерал Ч.Сайнтөр, хурандаа В.Пүрэвбаасан, Ц.Эрдэнэ, А.Энхтөр, Х.Асхар, Б.Лувсанравдан, М.Баярсайхан, С.Энхсүх, Б.Амармэнд, Б.Мөнхбат, Е.Берикжан нар Хил судлалын ухаанаар докторын зэрэг амжилттай хамгаалсан бөгөөд хил судлалын докторантууд болох хурандаа Г.Ган-Эрдэнэ, Ж.Болдбаатар, Г.Гантулга, Д.Алтангэрэл, Г.Галбадрах, Л.Лхагвасүрэн, Т.Баяр-Эрдэнэ нар диссертациа шүүн хэлэлцүүлэх шатандаа явж байна.

Хил судлалын ухаанаар эрдмийн зэрэг, цол хамгаалахад Дотоод хэргийн их сургуулийн удирдлага, эрдмийн хамт олон, түүний дотор академич Ж.Амарсанаа тэргүүтэй хамгаалуулах зөвлөл, түүний гишүүдийн гүйцэтгэж байгаа үүрэгт Монголын нийт хилчид талархалтай хандаж байгааг тэмдэглэж байна.



График-1. Хил судлалын шинжлэх ухаанаар магистрын зэрэг хамгаалсан төгсөгчдийн тоо
Эх сурвалж: (М.Баярсайхан, 2019)

Хил судлалын магистрын сургалтын хөтөлбөрийг 2013, 2015, 2018, 2025 онуудад тус тус шинэчлэн сайжруулалт хийж, 2022 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр 5 жилийн хугацаатай магадалсан.

Манай эрдэмтдийн бүтээл, туурвилд тоо, чанарын өөрчлөлт гарч хил судлалын

ухаанаар нэг сэдэвт болон судалгааны ном, бүтээл, туурвилууд хэвлэгдэн эрдэм судлалын онол, практикийн асуудлуудаарх эх сурвалжууд өсөн нэмэгдэж олон улсын болон бүс нутаг, улс орон, байгууллагын түвшний эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнүүд тогтмол зохион байгуулагдаж байна.





График-2. Хил судлалын докторын сургалтад элссэн, хамгаалсан докторантуудын тоо
Эх сурвалж: (М.Баярсайхан, 2019)

Ийнхүү хил судлалын шинжлэх ухааныг Монгол Улсад нутагшуулж, төлөвшүүлснээр Монгол Улсын Шинжлэх ухааны орон зайд Хил судлалын шинжлэх ухаан өөрийн гэсэн байр сууриа баттай олсон гэж үзэх бүрэн үндэстэй болно. Хил судлалын ухааныг хөгжүүлэхэд дор дурдсан байгууллага, нэгжүүд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Хилийн цэргийн дээд сургууль, Цагдаагийн академитай 2011 онд нэгдэн Дотоод хэргийн их сургууль байгуулагдаж, хил судлалын онол, улсын хил болон хилийн орон зайд өрнөж байгаа үйл явцын

шинж байдал, мөн чанар, энэ орон зайд хамаарагдах бие хүн, улс төрийн ашиг сонирхлыг хамгаалж буй төр, олон нийт, хүчний болон бусад байгууллагын үйл ажиллагааг харьцуулан судалгааны тэргүүлэх чиглэлээ болгон эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулахаас гадна “Хил судлал” хөтөлбөрт суралцаж байгаа докторант, магистрантуудын ажлын явцыг хэлэлцэж зөвлөн туслах, санал шүүмж өгөх Хил судлалын судалгааны профессорын баг 2011 онд байгуулагдаж, одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.



16. ХИЛ СУДЛАЛЫН ПРОФЕССОРЫН СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ			
№	Свог, нэр	Эрдэмн болон боловсролын хэл, цол	Тайлбар
Тэргүүлэх профессор			
1.	Норовын Наранжавц	Цэргийн ухааны доктор, профессор	
Тэргүүлэх профессорын орлогч			
2.	Цэрэндэгвийн Олбазар	Цэргийн ухааны доктор	
3.	Павангийн Павансүрэн	Докторант	
Зөвлөх профессор			
4.	Дондовын Ганбаатар	Томьёоны ухааны доктор, профессор	
5.	Чойдмдагвийн Сайтсэр	Хил судлалын доктор, дэд профессор	
6.	Цагааны Ганболд	Цэргийн ухааны доктор, профессор	
7.	Асгарын Муретхан	Цэргийн ухааны доктор, профессор	
Гишүүд (Судалгааны чиглэл хариуцсан профессор, дэд профессор)			
8.	Баачгийн Жааханцогт	Цэргийн ухааны доктор, дэд профессор	
9.	Боржигонийн Лувсанравдан	Хил судлалын доктор	
10.	Жагдарсэйн Ог-оюунсүрэг	Цэргийн ухааны доктор, профессор	
11.	Намжавсэйн Давандорж	Цэргийн ухааны доктор	
12.	Мэлчиддорж Баярсайхан	Хил судлалын доктор	
13.	Цэрэндоржийн Гансүх	Аюулгүй байдлын доктор	
14.	Елооны Хадхүү	Хил судлалын доктор	
15.	Гэрэлтийн Хулан	Аюулгүй байдлын доктор	
16.	Шархүүгийн Чүлүмбат	Хууль зүйн доктор, дэд профессор	
17.	Балдандоржийн Буя	Боловсрол, судлалын доктор	
Туслах сургууль, танхим			
18.	Хилийн албаны сургууль	Сургуулийн захирал	Саналын эрхтэй
19.		ХАС-ийн болон АМСУТ-ийн холбоотой танилцуул багш	Хуралдаанд өргөтгөж оролцоно.
дотоод хэргийн их сургууль			

Зураг-2. Хил судлалын профессорын судалгааны багийн бүрэлдэхүүнийг томилсон тухай тушаал

Эх сурвалж: (Дотоод хэргийн их сургуулийн захиралын тушаал, 2024)

Хил Хамгаалах Байгууллагаас төрсөн эрдэмтдийн санал санаачилгаар, Монгол Улсад Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, хил хамгаалалтад шинжлэх ухаанч хандлага төлөвшүүлэн, шинэ техник технологи нэвтрүүлж, хилийн аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагааг мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилан зохион байгуулах зорилгоор 2000 онд байгуулагдсан “Хил судлалын үндэсний нийгэмлэг”-ийг “Монголын Хил Судлалын Академи” болгон өөрчлөн зохион байгуулж, 2016 оны 7 дугаар сарын 1-нд

нээлтээ хийж анхны хуралдаанаа хийж, дүрмээ баталсан. (Д.Нямдорж, 2017)

Улмаар 2025 онд Хил судлалын академийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, хилчин эрдэмтдийн судалгаа, бүтээл, туурвилуудыг практикт нэвтрүүлэх, хил хамгаалах бодлого, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт эрдэмтдийн уулзалт зохион байгуулж, зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал солилцсон.

Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх эрдэм шинжилгээ, судалгааны



დავყენებ ჩემს ძალს ჩემთვის

нэгж нь хил судлалын шинжлэх ухаантай хамт зэрэгцэн хөгжиж, анх 1980 онд МАХН-ын Улс төрийн товчооны 174 дүгээр тогтоолоор “Улсын хилийн түүхийг судлах групп” нэртэйгээр байгуулагдаж байсан бол Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар “Хилийн цэргийн хил судлалын хүрээлэн” болгон өөрчлөн зохион байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. (М.Уранбайгаль, 2021)

Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүний онол, арга зүйн үндсийг боловсруулах, суурь судалгаа хийх зорилго бүхий эрдэм шинжилгээний бүтцийн нэгж нь Хилийн цэргийн дээд сургуульд Эрдэм шинжилгээний төв нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Дотоод хэргийн их сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2012 оны 10 дугаар тогтоолоор Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бүтцэд Хил судлалын төв байгуулагдаж, Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэн, Хилийн аюулгүй байдал судлалын төв болон өөрчлөгдөн хил судлалын ухааны түшиг төв болон ажиллаж байна. (ДХИС, 2024) Түүнчлэн Хил судлалын ахисан түвшний сургалтыг Дотоод хэргийн их сургуулийн Ахисан түвшний сургалт, судалгааны алба, Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхим, Хилийн албаны сургуулийн Хилийн албаны болон бусад мэргэжлийн тэнхимүүд эрхлэн явуулж байна.

Хил судлалын ухаанаар сүүлийн жилүүдэд онол, практикийн асуудал хөндсөн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс дурдвал:

Ш.Арвай – “Хилчний сурах бичиг”, “Монгол Улсын тусгаар тогтнол ба улсын хил”, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”;

П.Даш-“Хилийн харуул”, “Хил хамгаалалтын онол”, “Улсын хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндэстэй удирдъя”, “Телехяналтын өмнөх хилийн харуул”;

С.Гүржав- “Хилчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг албанд харгалзан үзэх нь”

Ц.Ганболд- “Хил судлал”, “Штабын сургалт бэлтгэл”, “Хилийн аюулгүй байдал”, “Хаант Орос-Манж Чин улсын хилийн харилцааны түүхэн тойм (1689-1911 он)”;

Н.Наранжамц- “Хилийн операци”, “Улсын хил хамгаалалтын онол-практикийн үндсэн асуудлууд”, “Бүс нутаг-хил хамгаалалтын үзэл баримтлал”;

Ш.Арвай, Н.Наранжамц,
А.Муратхан, Д.Нямдорж нарын хамтын
бүтээл- “Улсын хил судлал: онол,
практикийн зарим асуудал”;

Д.Ганбаатар- “Хилийн заставын материал-техникийн хангалт”, “Системийн онолыг Хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн материал-техникийн хангалтад ашиглах нь”;

Д.Нямдорж -“Улсын хилийн инженер техникийн хангалт”;

Ж.Өвгөнбүргэд- “Монгол улсын хилийн аюулгүй байдлын онолын үндэс”;

Ч.Сайнтөр- “Хил хамгаалах
байгууллагын хүний нөөцийн хөгжлийн
асуудал”;

А.Энхтөр-“Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал”;

Ц.Одбаяр -“Хилийн аюулгүй байдал-
Тусгай томилгоот салбар”;

Ё.Хадхүү- “Улсын хил, түүний тухай ерөнхий ойлголт”;

Х.Асхар- “Хилийн боомтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал”;

Г.Хулан-“Хүний аюулгүй байдал” зэрэг бүтээлүүдээс гадна бусад олон бүтээл, туурвилууд гарсаар байгаа нь хил судлалын шинжлэх ухааны мэдлэгийн сан улам бүр баяжсаар байна.

Дүгнэлт, санал

Монгол улсад хилийн шинжлэх ухааныг үүсгэн байгуулж, төлөвшүүлж, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэд, мэргэдээс Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Ш.Арвай, А.Муратхан, гавьяат багш Н.Наранжамц, гавьяат холбоочин, доктор Ц.Цэрэндорж, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан 10 гаруй эрдэмтэд төрөн гарч, Шинжлэх ухааны академийн бага хурлын чуулганы гишүүнээр доктор, профессор



Хил судлалын шинжлэх ухааны тухайн хууль

Ц.Ганболд ажиллаж, Дотоод хэргийн их сургуулийн эмерит болон хүндэт профессороор 5, хүндэт доктороор 2 эрдэмтэн тус тус өргөмжлөгдөж, хил судлалын ухааны магистр, докторын сургалтад суралцахаар элсэгчдийн тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Хил хамгаалах байгууллагын удирдлагын бодлогоор хил судлалын болон зарим шинжлэх ухааны чиглэлээр “Өдрийн доктор”-ын сургалтад элсүүлэн суралцуулж байгаа, оператив-тактикийн түвшний офицеруудыг Хил судлалын магистрын хөтөлбөрт тогтмол элсүүлэн суралцуулахын зэрэгцээ зарим төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, дэмжин ажилладагт Хилчин-эрдэмтэд талархаж байдаг болно.

Нөгөө талаар хил судлалын ухааныг хөгжүүлэх, эрдэм судлалыг арвижуулахад ДХИС-ийн удирдлага, эрдмийн хамт олон хичээл зүтгэл гаргаж, тусалж дэмжиж, ахисан түвшний боловсрол олгоход мэргэжил арга зүйгээр чиглүүлж ажилладагт хилчид талархаж явдаг юм.

Хил судлалын шинжлэх ухааныг гүнзгийрүүлэн өргөжүүлж, хөгжүүлэхэд ХХЕГ, ДХИС, Хил судлалын хүрээлэн төвүүд, Хилчин-эрдэмтэд хүчин чармайлтаа нэгтэн ажиллах шаардлагатай бөгөөд “Хил судлалын шинжлэх ухааны тэмдэглэлт өдөр”-тэй болох, Хилчин-эрдэмтдийн бүтээл, туурвилыг хөхүүлэн дэмжих, албан тушаал, зэрэг дэв ахихад Хил судлалын ухаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан үзэх нь зүйтэй болно.

Энэ өдрүүдэд тохиож байгаа “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Хил хамгаалах байгууллагаас төрсөн нийт

эрдэмтэд, залуу судлаачдад эрдэм судлалд нь өндөр амжилт хүсэж, Хил судлалын шинжлэх ухаанд хувь нэмрээ оруулан улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад онол, практикийн бүтээл, туурвилаа зориулан ажиллахыг хүсэн ерөөе.

Эх сурвалжийн жагсаалт

БСШУ-ны Сайдын тушаал. (2010).

Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны яам.

https://moe.gov.mn/posts?page=6&category_id=11834-ээс Гаргасан

Д.Нямдорж. (2017). Монголын Хил Судлалын академи нээлтээ хийлээ. *Хил шинжлэл, 1*, 8.

Дотоод хэргийн их сургуулийн захиралын тушаал. (2024).

ДХИС. (2024). *Тусгаар тогтнолын дархлааг тогтоогчид. 2011-2024 оны түүхий альманах.*

М.Баярсайхан. (2019). *Хил судлалын магистр, докторын сургалтын хөтөлбөрийн танилцуулга.*

М.Уранбайгаль. (2021). Шинжлэх ухаанд суурилсан хил хамгаалалт. *Хилчин, 02*.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. (2002). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203037>-ээс Гаргасан

Хил судлал. (2000). 3.

Ц.Ганболд. (2022-12-02). Хил судлалын шинжлэх ухааны үүсэл хөгжил, чиг хандлага.

<https://www.uia.gov.mn/news/935>-ээс Гаргасан